



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 5/05

Баянхутаг сум

Ажил хариуцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, Монгол Улсын Их хурлын 2012 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, албан тушаалтнуудын хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар Засаг даргын тамгын газрын дарга Гүрбадамын Болдыг томилсугай.

2. Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар Засаг даргын тамгын газрын дарга Г.Болдыг 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс сарын үндсэн цалингийн 40 (дөх) хувиар цалинжуулж ажиллахыг Нягтлан бодогч /Г.Пүрэвдулам/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАЙГАЛМАА